

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Байгаль хамгаалалтын захиргаа ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОО-2025/010/НА-СТА-ОНӨААТҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2025 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4204 Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.03.17 № 407

танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМГИЙН БАЙГАЛЬ
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГАА
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Б.ЭРДЭНЭБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дорнод аймгийн Байгаль хамгаалалтын захиргаа” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлын онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

011022194

Бусад асуудлын хэсэг

“Дорнод аймгийн Байгаль хамгаалалтын захиргаа” ОНӨААТҮГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилго, 8 зорилтыг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Засаг даргын тамгын газраас 90.0 хувьтай үнэлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>23,987,540.80</u>	<u>11,792,597.80</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	10,000.80	25,057.80
312	Банканд байгаа бэлэн мөнгө	10,000.80	25,057.80
3121	Төгрөг	10,000.80	25,057.80
31213	Арилжааны банк дахь харилцах	10,000.80	25,057.80
35	БАРАА МАТЕРИАЛ	23,977,540.00	11,767,540.00
354	Хангамжийн материал	23,977,540.00	11,767,540.00
35410	Бичиг хэргийн материал	145,000.00	145,000.00
35420	Аж ахуйн материал	22,072,540.00	10,412,540.00
35430	Сэлбэг хэрэгсэл	660,000.00	660,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,100,000.00	550,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>148,814,338.54</u>	<u>129,697,758.34</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	148,814,338.54	129,697,758.34
392	Биет хөрөнгө	147,614,338.54	128,797,758.34
39203	Авто-тээврийн хэрэгсэл	115,743,395.13	115,743,395.13
39204	Хуримтлагдсан элэгдэл	(17,057,672.89)	(28,632,012.49)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	39,690,400.00	39,690,400.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(6,965,659.18)	(12,152,649.94)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,815,000.00	1,815,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(601,124.52)	(782,624.28)
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,990,000.00	14,990,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,873,750.08)
393	Биет бус хөрөнгө	1,200,000.00	900,000.00
39301	Програм хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(300,000.00)	(600,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>172,801,879.34</u>	<u>141,490,356.14</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>172,801,879.34</u>	<u>141,490,356.14</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	172,801,879.34	141,490,356.14
512	Хуримтлагдсан үр дүн	172,801,879.34	141,490,356.14
51210	Өмнөх үеийн үр дүн	180,674,408.66	172,801,879.34
51220	Тайлант үеийн үр дүн	(7,872,529.32)	(31,311,523.20)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>172,801,879.34</u>	<u>141,490,356.14</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	179,762,631.00	191,253,990.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	37,640,200.00	27,263,720.00
120	Нийтлэг татварын бус орлого	37,640,200.00	27,263,720.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	37,640,200.00	27,263,720.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,650,200.00	27,263,720.00

Дорнод аймгийн Байгаль хамгаалалтын захиргаа ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	14,990,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	142,122,431.00	163,990,270.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	142,122,431.00	163,990,270.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	142,122,431.00	163,990,270.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	187,635,160.32	222,565,513.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	187,635,160.32	222,565,513.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	187,635,160.32	222,565,513.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	93,210,709.20	132,542,824.00
210101	Үндсэн цалин	93,210,709.20	132,542,824.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,342,719.00	15,911,750.00
210201	Тэтгэврийн даатгал	11,342,719.00	15,911,750.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,179,407.00	17,805,047.00
210401	Бичиг хэрэг	304,200.00	485,300.00
210402	Тээвэр, шатахуун	6,166,118.00	4,097,847.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	514,800.00	471,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	814,289.00	540,000.00
210408	Бараа материал акталсны зардал	7,380,000.00	12,210,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,016,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	2,016,000.00	3,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,968,000.00	2,300,000.00
210702	Дотоод албан томилолт	2,968,000.00	2,300,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,675,495.00	31,889,312.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,694,178.00	26,695,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	4,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	64,350.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	111,812.00	111,612.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	440,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	47,155.00	44,100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	16,000.00	32,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,242,830.12	19,116,580.20
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,242,830.12	19,116,580.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(7,872,529.32)</u>	<u>(31,311,523.20)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(7,872,529.32)</u>	<u>(31,311,523.20)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>164,772,631.00</u>	<u>191,253,990.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,650,200.00	27,263,720.00
120	Нийтлэг татварын бус орлого	22,650,200.00	27,263,720.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22,650,200.00	27,263,720.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,650,200.00	27,263,720.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	142,122,431.00	163,990,270.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	142,122,431.00	163,990,270.00

Дорнод аймгийн Байгаль хамгаалалтын захиргаа ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	142,122,431.00	163,990,270.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>164,772,330.20</u>	<u>191,238,933.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>164,772,330.20</u>	<u>191,238,933.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>164,772,330.20</u>	<u>191,238,933.00</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	93,210,709.20	132,542,824.00
210101	Үндсэн цалин	93,210,709.20	132,542,824.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,342,719.00	15,911,750.00
210201	Тэтгэврийн даатгал	11,342,719.00	15,911,750.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,799,407.00	5,595,047.00
210401	Бичиг хэрэг	304,200.00	485,300.00
210402	Тээвэр, шатахуун	6,166,118.00	4,097,847.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	514,800.00	471,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	814,289.00	540,000.00
2105	Нормативт зардал	1,100,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,100,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,676,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	2,676,000.00	3,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,968,000.00	2,300,000.00
210702	Дотоод албан томилолт	2,968,000.00	2,300,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,675,495.00	31,889,312.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,694,178.00	26,695,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	4,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	64,350.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	111,812.00	111,612.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	440,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	47,155.00	44,100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	16,000.00	32,600.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>300.80</u>	<u>15,057.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	300.80	15,057.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,700.00	10,000.80
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,000.80	25,057.80

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	172,801,879.34	172,801,879.34
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	172,801,879.34	172,801,879.34
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	(31,311,523.20)	(31,311,523.20)

2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	141,490,356.14	141,490,356.14
---------------------------------------	------	----------------	----------------

2.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өөрчлөлт	/төгрөгөөр/ хувь
НИЙТ ОРЛОГО	170,623,900.00	191,253,990.00	(20,630,090.00)	112.09
I. ОРЛОГЫН ДҮН	170,623,900.00	191,253,990.00	(20,630,090.00)	112.09
Үндсэн үйл ажиллагааны орлого	170,623,900.00	163,990,270.00	6,633,630.00	96.11
Туслах үйл ажиллагааны орлого		27,263,720.00	(27,263,720.00)	
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	170,623,900.00	191,238,933.00	(20,615,033.00)	112.08
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	170,623,900.00	191,238,933.00	(20,615,033.00)	112.08
Үндсэн цалин	143,592,600.00	132,542,824.00	11,049,776.00	92.30
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөгдөх шимтгэл	17,949,200.00	15,911,750.00	2,037,450.00	88.65
Хангамж бараа материалын зардал	6,003,800.00	5,595,047.00	408,753.00	93.19
Бичиг хэрэг	350,000.00	485,300.00	(135,300.00)	138.66
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	600,000.00	471,900.00	128,100.00	78.65
Тээвэр, шатахуун	4,350,000.00	4,097,847.00	252,153.00	94.20
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	703,800.00	540,000.00	163,800.00	76.73
Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	3,000,000.00	(2,500,000.00)	600.00
Урсгал засвар	500,000.00	3,000,000.00	(2,500,000.00)	600.00
Томилолт, зочны зардал	1,490,000.00	2,300,000.00	(810,000.00)	154.36
Дотоод албан томилолт	1,490,000.00	2,300,000.00	(810,000.00)	154.36
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,088,300.00	31,889,312.00	(30,801,012.00)	2,930.19
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж		26,695,000.00	(26,695,000.00)	
Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	280,000.00	4,500,000.00	(4,220,000.00)	1,607.14
Даатгалын үйлчилгээ	83,300.00		83,300.00	-
Татвар	115,000.00	111,612.00	3,388.00	97.05
Тээврийн хэрэгслийн оношилгоо	70,000.00	66,000.00	4,000.00	94.29
Банк хураамж	70,000.00	44,100.00	25,900.00	63.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	440,000.00	0.00	100.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	30,000.00	32,600.00	(2,600.00)	108.67

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 19.1 сая төгрөгийн 1 зөрчил¹ илэрсэнд албан шаардлага өгсөн.

1. Томилолтын 14.1 сая төгрөгийн хуудсыг бүрэн бөглөөгүй, анхан шатны баримтын иж бүрэн байдал хангалтгүй, Цахим төлбөрийн баримтыг ерөнхий журнал дахь худалдан авалттай тулгахад 5.0 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зарлагын гүйлгээ хийсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхан шатны баримтын иж бүрэн байдал хангалтгүй	1	19,080.0			1	19,080.0	-	-	-	-	-	-
Дүн	1	19,080.0			1	19,080.0	-	-	-	-	-	-



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 3 сарын 15 өдөр

Дугаар 114/19925199

Чойбалсан хот

2025-2025/090/НА-СГА-ОНОВТ

Г Зөрчил арилгах тухай 7

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Байгаль хамгаалалтын захиргаа ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Томилолтын 14,080,000.00 төгрөгийн хуудсыг бүрэн бөглөөгүй, анхан шатны баримтын иж бүрэн байдал хангалтгүй, Цахим төлбөрийн баримтыг ерөнхий журнал дахь худалдан авалттай тулгахад 5,000,000.00 төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу зарлагын гүйлгээ хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төсвийн ерөнхий ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.8-д "Анхан шатны баримт, нягтлан бодох бүртгэлийн данс, санхүүгийн тайлан, тооллого тооцооны бүх баримтыг төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу хөтөлж, эмхлэн цэгцэлж, бүрэн гүйцэт бүрдэлтэйгээр архивд актаар шилжүүлэх", 4.2.1-т "Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлан балансын гаргалт, тооллого тооцоо, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг өөрийн болон харьяа байгууллагадаа байнга шалган зааварчилж байх" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан

2125040563

шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.1-д “Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн заалтыг мөрдөж ажиллах, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль хамгаалалтын захиргаа ОНӨААТҮГ-ын захирал Б.Эрдэнэбаяр, нягтлан бодогч Д.Сэвжил нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Э.НАНДИНЧИМЭГ

